



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 654

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 77 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 29,400,000.00 (хорин есөн сая дөрвөн зуун мянган) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дугаар сарын 08 -ны өдрийн  
054 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Тоёота клугер (автомашин)	ш	1	29,400,000.00	29,400,000.00
	Нийт дүн				29,400,000.00 (хорин есөн сая дөрвөн зуун мянган)